

2025 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 61

Улаанбаатар хот

Сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалт, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, “Худалдаа, хөгжлийн банк” ХК (цаашид “Банк” гэх)-ийн дүрмийн 8 дугаар 8.11.20 дахь заалтыг тус тус үндэслэн Худалдаа, хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. Банкны холбогдох этгээд болох “Ти Ди Би Секьюритис ҮЦК” ХХК-д тус банкны эзэмшиж буй “Зээлийн мэдээллийн төв” ХХК /РД: 5294797/-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 31.5 хувьтай тэнцэх 406,416 ширхэг хувьцааг худалдахыг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д зөвшөөрсүгэй.

2. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотой хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, хэлцэл болон холбогдох бусад баримт бичигт Худалдаа, хөгжлийн банкныг төлөөлөн гарын үсэг зурах, холбогдох этгээдэд дамжуулан итгэмжлэл олгох болон шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах эрхийг Гүйцэтгэх захирал (О.Орхон)-д олгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Ажлын алба (Н.Нямсүрэн)-нд даалгасугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



РАНДОЛФ КОППА